

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ  
 НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2016 ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Чойр

№	Хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	Хугацаа	Биелэлт	Хувь
<b>Нэг. Эрүүл мэндийг хамгаалах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд</b>				
1.	Албан хаагчдыг жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт бүрэн хамруулах;	Тухайн жилдээ	Байгууллагын албан хаагчдыг жилийн эцэст эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.	
2.	Албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх зорилгоор бусад байгуулагатай гэрээ байгуулан ажиллах;	I улирал	Албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх зорилгоор Мэргэжилийн хяналтын газартай хамтран 8 удаа спорт зааланд чөлөөт цагаа өнгөрүүлсэн Усан спорт сургалтын төвд 3 албан хаагч 7 хоног бүр тогтмол хичээллэж байна.	100%
3.	Жил бүр УБСЕГазраас зохион байгуулсан урлаг-спортын арга хэмжээнд идэвхитэй оролцох	III улирал	Одоогоор УБСЕГазраас Урлаг спортын арга хэмжээ зохион байгуулаагүй байна.	
4.	Албан хаагчдад эрүүл агаарт амарч байгалийн үзэсгэлэнт газруудаар тойрон аяллыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах;	III улирал	Газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг аялалын дагуу нийт албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр 7-р сард байгалийн үзэсгэлэнт газар болох Итгэлт хамбруу аялахыг төлөвлөж байна. Ажилчдын амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, найрсаг хамт олон болох нөхцлийг бүрдүүлэх зорлигоор 5 сард бүх албан хаагчид "Цоорхой рашаан"-д очсон.	100%
5.	Хортой нөхцөлд ажиллаж байгаа албан хаагчдад сүү өгөх;	Улирал бүр	Хортой нөхцөлд ажиллаж байгаа албан хаагчдад сүү өгсөн.	100%
6.	Спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Тухай бүр	2 удаа албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан.	100%
7.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу албан хаагчдын цалин болон нэмэгдлийг тухай бүр шинэчлэн олгох;	I улирал	2016 онд 3 удаа албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон. Үүнд: 1. УБСЕГазар 2016.03.21 13 албан хаагч	100%

			2.УБСГазар 2016.05.02 Б/08 1 албан хаагч 3. УБСЕГазар 2016.06.03 Б/208 3 албан хаагч	
8.	Төрийн захиргааны албан тушаалд нэг жилээс багагүй хугацаагаар ажиллаж байгаа албан хаагчдыг тангараг өргүүлэх үйл ажиллагааг Бүртгэлийн байгууллагын ажилтны өдрөөр зохион байгуулах;	Тухай бүр	Туршилтын журмаар ажиллаж байгаа албан хаагч байхгүй байна.	-
9.	Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сард нэгтгэн дүгнэж цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан УБЕГазарт хүргүүлэх;	IV улирал	Хугацаа болоогүй 4 –р улиралд	-
10.	Байгууллагын хэмжээнд ажил үйлсээрээ шалгарсан албан хаагчийг шалгаруулан урамшуулах;	IV улирал	Хугацаа болоогүй	-
11.	Жил бүрийн хүүхдийн баяр болон шинэ жилээр албан хаагчийн 0-16 насны хүүхдэд баярын бэлэг өгөх;	Тухай бүр	Хүүхдийн баяраар нийт 37 бэлэг бэлдсэн. Үүнд: ✓ Газрын албаны ажилчдын 33 бэлэг өгсөнөөс байгууллага бэлэгний мөнгөний 50% нь гаргасан, ✓ Хүүхэд гэр бүл хөгжлөөс зохион байгуулсан уралдаанд оролцсон 2 хүүхдэд бэлэг өгсөн. ✓ Жил бүр уламжлал ёсоор эмзэг бүлгийн хүүхдүүдэд 2 бэлэг өгсөн.	100%
12.	Жил бүрийн эхэнд албан хаагчдын ээлжийн амралтыг газрын даргын тушаалаар батлах бөгөөд хуваарийн дагуу амраана. Хэрэв ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тохиолдолд тухайн албан хаагчид 1,5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тусламж олгоно.	I улирал	2016 оны албан хаагчдийн ээлжийн амралтын хуваарийг газрын даргын тушаалаар баталж, өнөөдрийн байдлаар 6 албан хаагч ээлжийн амралтаа эдлээд байна.	100%
13.	Ахмадын баяр болон цагаан сараар газрын ахмадуудад хүндэтгэл үзүүлнэ	Тухай бүр	Цагаан сар, Ахмадын баяраар ахмадуудад хүндэтгэл үзүүлэх зорлигоор Төрийн сан дахь Ахмадын санд 140438.11 төгрөг шилжүүлсэн боловч одоохондоо Сангийн яам татан авсан учраас гүйлгээ хийгдээгүй байна.	-
14.	Гэр болон галлагаатай байр,сууцанд амьдардаг	IV улирал	Хугацаа болоогүй	100%

	албан хаагчдын судалгаа гаргаж жил бүр түлээ, нүүрсний үнийн зохих хөнгөлөлт үзүүлэх			
15.	Албан хаагчдыг ажилдаа ирж очих унааны зохих хувийг байгууллагын зүгээс даах	Тухай бүр	Санал ирээгүй байна.	-
16.	Албан хаагчдын гэр бүлд шинээр мэндэлсэн хүүхдэд санхүүгийн бодитой дэмжлэг үзүүлэх	Тухай бүр	Шинээр хүүхэд мэндлээгүй байна.	-
17.	Төрийн албан хаагчдын өрхийн зарлагыг бууруулах, орлогыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх зорилгоор туслах аж ахуй эрхлэх, ногоо тарихад нь газар, ногооны үр өгөх зэргээр дэмжлэг үзүүлэх;	ii улирал	Одоогоор хүсэлт ирээгүй байна	-
18.	Ээлжийн амралтаар өөрийн буюу эхнэр / нөхөр / ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг тухайн үеийн тээврийн хэрэгслийн дундаж үнэлгээгээр тооцож олгох;	Тухай бүр	Одоогоор хүсэлт ирээгүй байна	-
19.	Төрийн албан хаагчдад орон сууцны зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох төсөлд албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах;	Тухай бүр	Одоогоор хүсэлт ирээгүй байна	-
20.	Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн албан хаагчдыг хамруулах орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт албан хаагчдыг идэвхитэй хамруулах;	Тухай бүр	Тус байгууллагын нийт албан хаагчдын 85% орон сууцанд амьдардагаас 45% нь орон сууцны зориулалтаар хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан байна.	100%
21.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх хуулиар олгогдсон нэг удаа үнэгүй газар өмчлөх эрхийг хэрэгжүүлэхэд нь нэгдсэн бодлогоор туслалцаа үзүүлэх;	Тухай бүр	Албан хаагчдаас хүсэлт ирээгүй	-
22.	Сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдад хэрэгцээтэй цаг үеийн шаардалагатай мэдээллээр сургалт явуулах;	I-IV улирал	-Аймгийн архивын тасгаас авсан захиалгын дагуу Үндэсний архивын газарт "Архивын шинэчлэл, Хөтлөх нэрийн жагсаалт, бүрдэл" сэдэвт сургалтанд газрын архивч Ариунаа, бичиг хэргийн ажилтан П.Насан-эрдэнэ нар 2016 оны 03 сарын 28-29-ны өдрүүдэд хамрагдсан. -"Статистикийн тухай хууль"-д аж ахуйн нэгжийн тооллогыг 2016 оны 04 сарын 1-нээс 5 сарын 1-ны хооронд багтаан	100%

			явуулах 3Г-аас шийдвэр гарсан. Тооллогын бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2016 оны 03 сарын 31-ны өдөр УБСГ-аас сумдын санхүү албаны дарга, сумдын улсын бүртгэгч, статистикийн ажилтан нарт сургалт хийсэн. -Аймгийн ЗДТГазрын Архивын тасгаас "Бичиг хэргийн стандарт, хэрэгжилт" гэсэн сэдэвт архивч, бичиг хэргийн сургалтанд хэлтсийн архивч Р.Ариунаа, бичиг хэргийн ажилтан П.Насанэрдэнэ нар оролцсон. Аймгийн УБСГ-ын мэдээлэл технологийн ажилтан нарт иргэний үнэмлэхний ИУБ-31 маягыг онлайнаар татаж авах тухай сургалтыг 2016 оны 05 сарын 16-ны өдөр хийсэн. МТАжилтан Э.Ганбаатар хамрагдсан.	
23.	Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа албан хаагчийг Удирдлагын академид мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулан төлбөрийг шийдэх;	Тухай бүр	Албан хаагчдаас хүсэлт ирээгүй	-
24.	Албан хаагчдыг бакалаврын болон магистрын мэргэжил ахиулах сургуульд суралцахад байгууллагын зүгээс дэмжих	Тухай бүр	Албан хаагчдаас хүсэлт ирээгүй	-
25.	Албан хаагчдыг урт, богино хугацааны төлбөртэй суралтанд хамруулах	Тухай бүр	Албан хаагчдаас хүсэлт ирээгүй	-
26.	Бүсчилсэн сургалтанд бүрэн хамрагдах		2016 онд бүсийн сургалт зохион байгуулагдах хуваарь гараагүй байна.	-
<b>Зургаа. Албан хаагчдын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:</b>				
27.	Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтны аливаа хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч түүний гэр бүлийн гишүүдийг шаардлагатай тохиолдолд хамгаалах ажлыг зохион байгуулна.	Тухай бүр	Албан тушаалтны аливаа хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч түүний гэр бүлийн гишүүдэд гараагүй байна.	-
28.	Хамтын сангийн хуримтлалтай болох	Сар бүр	2016 оны 2 улиралд хамтын сангийн хуримтлалын талаар 2 удаагийн хурлыг хийж, сар бүр 15000 төгрөг хураахаар тохиролцож, өнөөдрийн байдлаар 2310000 төгрөгний хуримтлал үүсээд	100%

			байна	
29.	Тэмдэглэлт баяр наадам болон газраас зохион байгуулагдаж буй аливаа ажилд нийт албан хаагчид бүрэн хамрагдах	Тухай бүр	2016 оны "Олон улсын эмэгтэйчүүдийн баяр", "Монгол цэргийн өдөр"-ийн баяр, "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" –ийн арга хэмжээг нийт албан хаагчид тэмдэглэсэн. Мод тарих өдөр болон нийтийн цэвэрлэгээний өдөр бүх албан хаагчид хамруулсан.	100%

#### Хөтөлбөрийн зорилтот үр дүн

- 2016 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөр хэрэгжиж дууссанаар дараах үр дүн гарсан байна.
- Албан хаагчдын эрүүл мэнд сайжирч, жил бүр нарийн мэргэжилийн эмчид үзүүлдэг хэвшил тогтоно.
- Албан хаагчдийг чийрэгжүүлэх зорилгоор холбогдох байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж тогтмолжсон байна.
- Үр дүнгийн гэрээгээр 90-100 оноо буюу "А" үнэлгээ авсан албан хаагчдад Төрийн албан хаагчдын үр дүнг үнэлж урамшуулах журмын дагуу цалингийн шатлал, зэрэг дэвийг ахиулах
- Засгийн газраас хэрэгжүүлж байгаа орон сууцны хөтөлбөрт орон сууцгүй албан хаагчийг хамруулсан байна.

#### Хөтөлбөрийн хамрах хүрээ:

Энэхүү хөтөлбөрт байгууллагын албан хаагчид хамрагдах бөгөөд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, тэдний биеийн эрүүл мэндэд байнга хяналт тавих, бие бялдарыг чийрэгжүүлэх, болзол нөхцөл хангасан тохиолдолд төрийн алба хаасан болон зэрэг дэвийн нэмэгдэл олгох, цалин хөлсний шатлал ахиулах, орон сууцны нөхцлөө сайжруулахад нь туслах зорилт чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хамтран ажиллаж харилцан мэдээлэл солилцох зэргээр газрын хэмжээнд тааламжтай уур амьсгалыг бүрдүүлнэ.

#### Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэх

Хөтөлбөр нь төсвийн шууд захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр үр дүн нь тооцогдоно.

Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтэнд газрын дарга хяналт тавина.

Хөтөлбөрийн хэрэгжилийн биелэлтийг хагас бүтэн жилээр дүгнэнэ

#### БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

#### БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

НЯГТЛАН БОДОГЧ  Ч. МӨНХДАЛАЙ

#### ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА  Л. ЦЭЛМЭГ